



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2015 оны 06 сарын 10 өдөр

Дугаар 271

Улаанбаатар хот

“Монголиан мортгэйж фонд ББСБ” ХХК-ийн
хаалттай өрийн бичгийг бүртгэх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, Компанийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1, Хорооны 2012 оны 248 дугаар тогтоолоор батлагдсан “Банк бус санхүүгийн байгууллагаас гаргах хаалттай өрийн бичгийг бүртгэх журам”-ын 2.8 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Монголиан мортгэйж фонд ББСБ” ХХК-ийн гаргасан 12 сарын хугацаатай 660,000,000 /зургаан зуун жаран сая/ төгрөгийн үнийн дүн бүхий хаалттай өрийн бичгийг бүртгэсүгэй.

2. Холбогдох хууль тогтоомж болон Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан журмаар хүлээсэн үүргээ чанд мөрдөж ажиллахыг “Монголиан мортгэйж фонд ББСБ” ХХК /Б.Жавзанпагма/-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Б.Батсэлэнгэ/-нд, үйл ажиллагаанд нь хяналт тавьж ажиллахыг Хяналт шалгалтын газар /Т.Жамбаажамц/-т тус тус даалгасугай.

ДАРГА



З.НАРАНТУЯА

000967